

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

"XIX.1. "Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл"-тэй холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүхээс гарсан шийдвэрийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Ганбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгав:

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д орсон "Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км замыг 4 эгнээтэй, цемент бетон хучилттай 1 дүгээр зэргийн авто зам болгон өргөтгөж шинэчлэх төсөл", "Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл"-үүд нь давхардал үүсгэх эрсдэлтэй байгаа тул асуудлыг шийдвэрлэх хувилбарын талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

2. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулах". гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР